Golomt Capital®

# ДЭЛХИЙН

## ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ



2025.08.18

# Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

**ТОВЧ**

- S&P 500 индекё түүхэн дээд ханшаа шинэчлэн тогтоолоо.
- 8-р сарын 21-23-нд болох Jackson Hole-н уулзалт анхаарлын төвд байна.
- АНУ-ын жижиглэн худалдааны компанидын тайлан энэ долоо хоногт зарлагдана.
- CME-ийн FedWatch-ийн тооцоогоор, зах зээлд 83% магадлалтайгаар 9-р сард хүү бууруулна гэж үзэж байна.
- Хятадын хагас дамжуулагчийн салбарын компаниудын хувьцаа хүчтэй өслөө.
- 7-р сард Хятадын эдийн засгийн өсөлт сулран, жижиглэнгийн худалдаа, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын өсөлт шинжээчдийн хүлээлтээс доогуур гарлаа.
- Хятадын хөрөнгийн зах зээл тарифын сунгалтаас болж түр зуурын өсөлт үзүүлсэн ч эдийн засгийн дотоодын үзүүлэлтүүд сул, хөрөнгө оруулагчдын итгэлд тодорхой эргэлзээ үлдээж байна.

**S&P 500 индексийн 2025 оны таамаглал**

| | |
|---|---|
| Deutsche Bank | 7,000 |
| Société Générale | 6,750 |
| BMO Capital Markets | 6,700 |
| Bank of America | 6,666 |
| Barclays | 6,600 |
| RBC Capital Markets | 6,600 |
| Wells Fargo | 6,500 |
| Citigroup | 6,500 |
| Goldman Sachs | 6,500 |
| Morgan Stanley | 6,500 |
| JPMorgan Chase | 6,500 |
| UBS | 6,400 |
| **Дундаж** | **6,678** |

Биткойны зорилтот ханш 134,500 ам.доллар.



# АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.08.11-08.15

## S&P 500 ИНДЕКС ТҮҮХЭН ДЭЭД ХАНШАА ШИНЭЧЛЭН ТОГТООЛОО

Өнгөрсөн долоо хоногт АНУ-н хөрөнгийн зах зээл шинэ дээд түвшинд хүрсэн бөгөөд S&P 500-ийн фьючерс 0.1%-иар өсч 6,479$ хүрсэн бол Nasdaq 100-ийн фьючерс 0.2%-иар өсч 23,845$ хүрэв. Ялангуяа Dow Jones индекс хамгийн өндөр өсөлттэй байсан бөгөөд үүнд Warren Buffett-ийн Berkshire Hathaway компани UnitedHealth Group (UNH)-д хувьцааны эзэмшилтэй болсон тухай мэдээ голлох нөлөө үзүүлэв.

## Jackson Hole-н уулзалт анхаарлын төвд байна.

Энэ сарын 8-р сарын 21-23 хооронд болох уг уулзалт нь Төв банкнуудын дарга нарын хооронд болдог эдийн засгийн форум юм. Зах зээлийн хамгийн том хүлээлт бол Холбооны Нөөцийн дарга Жером Пауэллын Жексон Хоулын уулзалтад хэлэх үг.

- Хөрөнгө оруулагчид 9-р сард 25 суурь нэгжээр хүүг бууруулна гэсэн итгэл үнэмшилтэй байгаа.
- Үүнд бага гарсан ажлын байрны тайлан болон 7-р сарын хэрэглээний инфляцын үзүүлэлт дэмжлэг үзүүлсэн.
- Гэхдээ өнгөрсөн долоо хоногийн үйлдвэрлэлийн үнийн индекс болох (PPI) өндөр гарсан нь энэ найдвар дээр тодорхой эргэлзээ төрүүлсэн.

Мөн энэ долоо хоногт гарах жижиглэнгийн худалдааны аварга компаниудын тайлангууд гарах ба эдгээрт: Walmart, Target, Home Depot, TJX, Lowe's гэх мэт багтаж байна. Энэ нь мэдээж хэрэглэгчдийн худалдан авах чадварын бодит дүр зургийг харуулах чухал үзүүлэлт болно.

## S&P 500 ИНДЕКСИЙН ХАНШИЙН ТӨЛӨВ



# Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.07.28 – 08.03

## БНХАУ-ЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ ДОЛОО ХОНОГИЙГ ӨСӨЛТТЭЙ ХААЛАА

Хятадын хөрөнгийн зах зээл энэ долоо хоногт өсөлттэй эхэллээ. Учир нь АНУ болон Хятад хоёр бие биенийхээ бүтээгдэхүүнд ногдуулах нэмэлт тарифыг 90 хоногоор түр хойшлуулахаар тохиролцсон нь хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлэв. CSI 300 индекс +2.37%, Хонг Конгийн Hang Seng индекс +1.65 хувиар тус тус өсөв.

Эдийн засгийн үзүүлэлтүүд: Уналтын шинжтэй

- Хэрэглээний үнийн индекс (CPI) 7-р сард жилийн дүнгээр өсөлтгүй, өмнөх сарын өсөлтөөс буурав.
- Үйлдвэрлэлийн үнэ (PPI) 34 дэх сардаа дараалан буурч, -3.6% болж хамгийн доод түвшинд хадгалагдав.
- Жижиглэнгийн худалдаа 3.7% өссөн нь 6-р сарын 4.8%-аас буурч, өнгөрсөн 12-р сараас хойших хамгийн удаан өсөлт болов.
- Аж үйлдвэрийн үйлдвэрлэл 5.7% өссөн ч өмнөх сарын 6.8%-аас суларлаа.
- Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт жилийн эхнээс 1.6% өссөн нь өмнөх жилийн 2.7%-аас доогуур гарчээ.

## ХЯТАДЫН ЧИП ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХУВЬЦАА ӨСӨВ

Хэд хоногийн өмнө Хятад-руу экспортлох Nvidia-н H20 чип болон AMD-н чипний борлуулалтын 15%-г АНУ-н ЗГ авч байх гэрээг байгуулж, Хятад руу экспортлох чипний урсгалыг дахин чөлөөтэй болгох шийдвэр гаргасан билээ. Гэсэн ч Хятадын зүгээс дотоодын чип үйлдвэрлэлээ дэмжиж, Америк чипийг ашиглахгүй ээ гэсэн мэдэгдэл хийгээд байна.

Мэдээлэл гарснаар: SMIC (HK:0981) – хувьцаа 4%, Hua Hong Semiconductor (HK:1347) – хувьцаа 4.5%, NAURA Technology (SZ:002371) – хувьцаа 2 хувиар тус тус өсөв.

Хятадын сэрэмжлүүлэг нь дотоодын чип үйлдвэрлэгчдийн эрэлтэд эерэг нөлөө үзүүлж, зах зээлд тэдний хувьцааны ханш богино хугацаанд огцом өсөхөд хүргэлээ.



### Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд




### Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

